



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Үндэсний хөтөлбөрийг дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” 03-03 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулахад дэмжиж ажиллах, батлагдаж хүчин төгөлдөр болсон хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, салбар хоорондын уялдааг сайжруулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч, холбогдох шийдвэр гаргаж ажиллахыг хорооны гишүүдэд даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга Г.Нямдаваа, Ж.Батбаясгалан нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ

